



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
Ц.МӨНХТУЯА ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 02. 10 № ХЗ/441  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Асуултын хариу хүргүүлэх  
тухай

Танаас 2025 оны 06 дугаартай албан бичгээр ирүүлсэн Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоолын талаарх асуултын хариуг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бэлтгэн ирүүлснийг Танд үүгээр хүргүүлж байна.

Хавсралт 04 хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265002286



**МОНГОЛ УЛСЫН  
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛТЫН САЙД**

Нэгдсэн үндэстний гудамж 5.  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, \*5160  
Утас 26 15159 Факс 77 80 4  
Цахим шуудан info@gerbul.mn  
Цахим хуудас www.mns.gov.mn

2026.02.10 № 01/473

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хариу хүргүүлэх тухай**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандан ирүүлсэн асуулгын хариуг ирүүлэх тухай ХЭГ/321 тоот албан бичигтэй танилцаад эрхлэх асуудлын хүрээнд хамаарах дараах хариуг хүргүүлж байна.

Төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо адил хөдөлмөрт ижил цалин хөлс олгох зарчмыг баримталдаг. Төрийн албан хаагчид олгох нэмэгдэл, тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох мөнгөн тэтгэмж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг Засгийн газраас тогтоосон албан тушаалын цалингийн хэмжээнээс тооцохоор шийдвэрлэсэн.

Төсвийн тухай хуульд заасны дагуу Боловсролын салбарын төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийг төлөвлөх, батлагдсан төсвийг хууль тогтоомжийн дагуу хуваарилах, хяналт тавих, захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрхтэй тул төрийн албан хаагчид олгох нэмэгдэл, төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн хэмжээг Боловсролын асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэгдүүлэн тогтоосон цалингийн хэмжээнээс тооцоход шаардагдах нэмэлт эх үүсвэрийн тооцооллыг тухайн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчаас авах нь зүйтэй байна.

Хүндэтгэсэн,



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам  
Сайд  
Т.Аубакир  
2026.02.10 16:48



**МОНГОЛ УЛСЫН  
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД**

Нэгдсэн үндэстний гудамж 5,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас: 26-15-53, Факс: 32-86-34,  
Цахим шуудан: info@mlsp.gov.mn  
Цахим хуудас: www.mlsp.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА  
С.БЯМБАЦОГТ ТАНАА

2026.02.09 № 01/445

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хариу хүргүүлэх тухай**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий Сайдад хандан ирүүлсэн асуулгын хариуг ирүүлэх тухай ХЭГ/321 тоот албан бичигтэй танилцаад эрхлэх асуудлын хүрээнд хамаарах дараах хариуг хүргүүлж байна.

“Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоол нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.14 дэх хэсгийг зөрчсөн эсэх, зөрчсөн тохиолдолд шинээр Засгийн газрын тогтоол батлуулах хугацааны мэдээлэл ирүүлэх тухайд:

Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор зарим салбарын санхүүжилтийн тогтолцооны шинэчлэлийг 2021 оноос эхлүүлсэн. Үүнтэй уялдуулан төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүн, гүйцэтгэлийг үнэлж үндсэн цалинг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх үүднээс 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг Засгийн газар тогтоохоор болсон.

Уг хуулийн өөрчлөлттэй холбогдуулан Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчдын цалингийн доод хэмжээг салбарын онцлогийг харгалзан нэмэгдүүлэн тогтоох эрхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт олгож байсан. Үүний дагуу Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/122 дугаар тушаалаар төрийн болон орон нутгийн өмчит сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн зарим албан хаагчийн цалингийн хэмжээг 2022 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Засгийн газраас тогтоосон албан тушаалын цалингийн доод хэмжээнээс дундажаар 15 хувиар нэмэгдүүлэн тогтоосон.

Дээрх жишгийн дагуу Засгийн газрын 2025 оны 224 дүгээр тогтоолоор шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээг салбарын хамтын хэлэлцээр, ажил мэргэжлийн онцлогийг харгалзан батлагдсан төсвийн багцдаа багтаан холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нар нэмэгдүүлэн тогтоохыг зөвшөөрсөн.

“Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Засгийн газрын 2025 оны 225 дугаар тогтоол нь төрийн албан хаагчид олгох нэмэгдлийг Засгийн газрын тогтоолоор баталсан албан тушаалын үндсэн цалингийн хэмжээнээс тооцохоор

заасан нь, мөн төрийн албан хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох нэг удаагийн буцалтгүй тусламж, тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн тэтгэмжийн хэмжээг Засгийн газраас тогтоосон албан тушаалын үндсэн цалингийн хэмжээнээс тооцохоор тус тус заасан нь боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн эрх зүйн байдлыг дордуулж байгаа тул шийдвэрээ эргэж харж, ямар зохицуулалт хийх талаар мэдээлэл ирүүлэх тухайд:

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад "Төсвийн удирдлагыг хэрэгжүүлэхэд төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн баталсан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлээр төсвийн бодлогыг тодорхойлж, түүнд үндэслэн аль ч шатны төсвийн эрх захирагч нь төсвийн тусгай шаардлагыг хангасан дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн үзүүлэлт болон түүнд нийцүүлэн баталсан төсвийн хязгаарт багтаан төсвийн төслөө зохиох зарчмыг баримтлах" гэж заасан.

Мөн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалтад "Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засгийн газар, Засаг даргын аливаа шийдвэр нь төсөвт үзүүлэх нөлөөллийн талаарх дүгнэлтэд үндэслэсэн байх" гэж, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтад бүх шатны төсвийн захирагч нь "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" үүрэгтэй гэж заасан.

Шинжлэх ухаан, эрүүл мэнд, боловсролын салбарын албан хаагчдын цалин хөлсийг 2026 онд нэмэгдүүлэх нэмэгдүүлэх чиглэлээр Эдийн засаг, хөгжлийн сайдын төсөвт 15 хувиар, Эрүүл мэндийн сайдын төсөвт 15 хувиар, боловсролын сайдын төсөвт 20 хувиар нэмэгдүүлэх төсөв тусгагдсан байна.

Гэвч "Боловсрол, шинжлэх ухааны яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны хооронд 2024-2026 онд байгуулсан хамтын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээрээр багш, ажилтны үндсэн цалингийн хэмжээг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 50 хувиар, 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс дахин 26 хувиар, "Эрүүл мэндийн салбарын 2024-2026 оны хамтын хэлэлцээр"-ийн нэмэлт хэлэлцээрээр эмч, ажилтны үндсэн цалинг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 30 хувиар, 2026 оны 08 дугаар сарын 01-ээс 2026 оны 12 дугаар сарын 01 хүртэл сар бүр 9 хувиар, Эдийн засаг, хөгжлийн яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбоо хоорондын 2026-2028 оны хамтын хэлэлцээрээр шинжлэх ухааны салбарын ажилтан, албан хаагчдын үндсэн цалинг 2026 онд 50-иас багагүй хувиар тус тус нэмэгдүүлэхээр тохиролцсон.

Дээр дурдсан яамдын хувьд 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд хэлэлцээрээр тохирсон хувиар албан хаагчдын үндсэн цалинг нэмэгдүүлснээр үндсэн цалингаас тооцох нэмэгдэл, нэмэгдэл хөлс мөн адил нэмэгдэж, цалин хөлсний зардал хэт нэмэгдэх, 2026 оны батлагдсан төсвийн хувьд хүндрэл үүсэх үр дагавартай тул цалин хөлсний бүтцийг оновчтой болгох бодлогын хүрээнд эдгээр салбарын албан хаагчдын нэмэгдлийн хэмжээг Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн захиргааны болон улс төрийн албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн доод хэмжээнээс тооцох шаардлага үүссэн.

Түүнчлэн боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарын албан хаагчдын нэмэгдлийг төсвийн ерөнхийлөн захирагчийн нэмэгдүүлэн тогтоосон албан тушаалын цалингийн хэмжээнээс тооцох нь бусад цалин нэмэгдээгүй соёл, спорт, цаг уур, орчны шинжилгээ, стандарт хэмжил зүй зэрэг төрийн мэргэжлийн

үйлчилгээний болон төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээнээс хэт зөрүү үүсгэхээр байна.

Иймд төрийн үйлчилгээг адил тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх, төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг гүйцэтгэдэг төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин хөлсийг тогтоохдоо адил хөдөлмөрт ижил цалин хөлс олгох зарчмыг хангах үүднээс төрийн албан хаагчид олгох нэмэгдэл, тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид олгох мөнгөн тэтгэмж, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон албан хаагчид олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийг тооцохдоо Засгийн газраас тогтоосон албан тушаалын цалингийн хэмжээнээс тооцохоор шийдвэрлэсэн байна.

Хүндэтгэсэн,



Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Сайд

Т.Аубакир

2026.02.09 14:53